АЖЛЫН БАЙРНЫ ЗАР · 2022 оны 12-р сарын 12

ПРОКУРОРЫН ТУСЛАХ АЖИЛТНЫ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР



Прокурорын туслах ажилтны ажлын байранд ажиллах хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор уг ажлын байранд ажиллах хүсэлтэй иргэдийн дунд сонгон шалгаруулалт зарлаж байна.

Шалгаруулалтыг Улсын ерөнхий прокурорын 2022 оны А/19 дугаартай тушаалаар батлагдсан "Прокурорын байгууллагын захиргааны албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх журам"-ын дагуу зохион байгуулна.

Шалгаруулалтад оролцогчид дараах материалыг бүрдүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн дотор Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг Багатойруу Хуульчдын гудамж 15/1 хаягаар эсхүл Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын 103 тоот өрөөнд хүлээлгэн өгнө үү. Үүнд:

-Төрийн албан хаагчийн анкет;

-Шалгалтад оролцохыг хүссэн өргөдөл;

-Шалгалтад оролцох иргэний гурван үеийн намтар;

-Бакалавр, түүнээс дээш боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн баталгаажуулсан хуулбар /гадаадад төгссөн бол баталгаат орчуулга/;

-Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар /төрийн албан хаагчид хамаарна/;

-Иргэний үнэмлэхийн хуулбар;

-Хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нотолсон баримт;

-Цээж зураг 4х6 см хэмжээтэй /3 хувь/;

-Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй бол баталгаажуулсан хуулбар;

-Төрийн албан хаагч, төрийн жинхэнэ албаны нөөцөд байгааг нотлох баримт;

-Цэргийн албыг биечилж болон дүйцүүлэн хаасныг гэрчлэх баримт бичгийн баталгаажуулсан хуулбар байна.

Шалгалт болох газар, цаг хугацааны талаарх болон бусад мэдээллийг Сонгон шалгаруулалтад оролцохоор бүртгүүлсэн иргэдийн цахим хаягаар мэдэгдэнэ.

Жич: Сонгон шалгаруулалттай холбоотой нэмэлт мэдээллийг Улсын ерөнхий прокурорын газрын хүний нөөцийн мэргэжилтэн Ш.Сийлэгмаатай /утас 88019466/ холбогдон авч болно.

Видео: https://www.youtube.com/watch?v=evyt8zezXno

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2056